



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/357

Мандалговь

“Хөгжилд хөтөлсөн залуу нас” ном
хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), 29.1.6 (г), Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 22 ний өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн иргэн Монгол Улсын үйлчилгээний Гавьяат ажилтан С.Үржингийн туурвисан аймгийн залуучуудын байгууллагын түүхэн хөгжлийн тухай “Хөгжилд хөтөлсөн залуу нас” номыг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Ном хэвлүүлэх зардалд шаардагдах 3,000,000 /Гурван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210424